

ЧИНГИС ХААН БА ИХ МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦАА

Л.Хайсандай

Энэ өгүүлэлд зөвхөн Чингис хааны үе буюу Их Монгол Улсын эхэн үеийн гадаад харилцааны хандлага, байдлын талаар товч авч үзэв. XIII зууны эхээр Монголын үндэсний тулгар төр, Их Монгол улс байгуулагдсан нь Төв Азийн нүүдэлчин овог угсаатнаар барахгүй Ази, Европ, Араб дахиныг нойрноос нь сэрээж, аугаа их хөдлөл, хөдөлгөөнд оруулсан түүхэн үйл явдлын эхлэл болсон юм.

Туурга тусгаар алив төр улсын гадаад бодлого, дипломат арга ажиллагаа нь, тухайн улсын орших ба эс орших, мандах ба буурах, бэхжих ба бутрах, хөгжих ба хоцрогдохын нэг чухал хүчин зүйл болдог. Тиймд алив улсын төрийн бодлого, дипломат үйл ажиллагаа нь улс үндэстнийхээ язгуур эрх ашгийг гуйвалтгүй дээдлэн, гадаад хүрээллийнхээ ашиг сонирхолыг хүндэтгэж харгалзан үзсэн, тун ухаалаг, эв эеийг эрхэмлэсэн байхыг шаарддаг. Ийм төлөв байдлыг Чингис хааны үеийн Их Монгол улсын дипломат арга ажиллагаа, гадаад харилцааны үйл замналаас төвөггүй олж харж болно.

Их Монгол Улсыг байгуулмагц Чингисийн өмнө гадаад бодлого, дипломатын хувьд нэн түрүүнд шийдвэрлэх хоёр чухал асуудал тулгарсан. Энэ нь нэгд, харийн нутагт зугатан гарч, тэндээс дайн түрэмгийлэл өдөөн заналхийлж байсан дайсагнагч хүчийг бут цохих; хоёрт, хөрш улсуудаар Их Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх явдал байв¹. Нэгдмэл төр улсаа байгуулснаар тэр үед цэрэг, улс төрийн хувьд бусдаас давуу байдал олж, хүчирхэгжиж байсан боловч Чингис хаан хөрш зэргэлдээ улс орнуудтай найрсаг харилцаатай байх, худалдаа арилжаа хийх, эрдэм соёлын солилцоо өргөн явуулах бодлого баримталж байжээ.

Чингис хаан гадаад орчинтой харилцах, улс хоорондын маргааныг шийдвэрлэхдээ юуны өмнө цэрэг зэвсгийн хүчийг урьдал болгодоггүй, харин эхлээд дипломат арга зам эрэлхийлэхийг эрхэмлэдэг байж. Өөрөөр хэлбэл, Чингис хааны үед улс хооронд бий болсон маргааныг шийдвэрлэхэд дипломат арга ажиллагааг чухалчилан үзэж, эцсийн бүлэгт тэр нь үр дүнгүй болсон нөхцөлд л цэрэг зэвсгийн

¹Л.Хайсандай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор /Sc./, профессор

хүч хэрэглэдэг байсныг түүхийн олон баримт нотолдог. Чингис хааны үед Монгол улс гадаад улстай харилцах асуудлыг дипломат арга хэлбэрээр шийдэх оролдлого хийж байсан нь тухайлбал, Дундад Азийн Хорезм буюу Сартуул улс, Хятадын Алтан улс, Сүн улстай явуулж байсан үйлдлээс тодорхой харагддаг. Ер нь Төв Азид Чингис Их Монгол улс байгуулаад гадаад ертөнцтэй өргөн харилцах үйл ажиллагаандаа тэр үеийн дипломат ёс зүйн хэм хэмжээний хүрээнд элч төлөөлөгч явуулах, зар бичиг илгээх, гэрээ хэлэлцээр байгуулах, найрамдан харилцах, зөвшилцөх, ятган өөртөө татаж дагуулах зэрэг олон улсын харилцааны сонгомол аргуудыг өргөн хэрэглэж, улс хоорондын харилцааг эвийн замаар зохицуулах оролдлого хийдэг байсан нь Монголын төрийн гадаад үйл хэргийн гол зарчим болсон төдийгүй өнөөгийн олон улсын харилцааны үндсэн хэлбэр болсон гэж болно.

Чингис хаан элчин харилцааг хамгийн чухалд үзэж “Элчин харилцаа бол төрийн алтан аргамжаа мөн” хэмээн эрхэмлэдэг байв. Тухайлбал, Чингис хаан элч илгээх, элчээр дамжуулж харилцах явдлыг “Алтан аргамжаа” хэмээн нэрлэж байсан нь Монголын нууц товчоонд тод томруунаар тэмдэглэгдсэн байна².

Ийнхүү Их Монгол улс элчин харилцааны бодлого, үйл ажиллагааг явуулж байсан олон баримт байдаг. Тухайлбал: Жубахан тэргүүтэй монголын элч нар Сүн улсад /Хятадын/ 1214 онд очиж найрамдалтай байх элчин харилцаа тогтоож байсан тухай Монголын нууц товчоо³ болон Чингис хааны тухай өгүүлсэн бусад ном зохиолд⁴ тэмдэглэгджээ.

Түүнчлэн Дорнод Туркестанд ноёрхож байсан Хар Кидан улсад 1209 онд Их Монгол Улсын элч явуулах, тэндээс хариу элч хүлээн авах, зар бичиг солилцох арга замаар тэр улсын зарим хэсгийг нь өөртөө дагуулан авч холбоотноо болгосон байна⁵.

Их Монгол улсад элч төлөөлөгчийн бүрэн эрхт, аюулгүй байдлыг хангах асуудлыг онцгой анхаарч, төр улсын бодлого, нэр алдар, ёс хүндэтгэлийн өндөр түвшинд тавьдаг байсан нь өнөөгийн олон улсын дипломат ёс горимын гол зүйл болон дэлхий дахинд хэвшин тогтжээ. Тэр үед Элч төлөөлөгчийн нэр сүрийг гутаасан, амь насыг хохироосон үйлдэл бүрийг “Төрийн алтан аргамжааг таслав” хэмээн томъёолж, төр улсын эсрэг үйл ажиллагаа гэж үздэг байсан бөгөөд тийм тохиолдлууд нь гол төлөв аян дайнд хүргэдэг байсан байна. Тухайлбал: Хорезм улсын Мухамед хаан руу илгээсэн Их Монгол улсын Элч нарын амийг хөнөөсөн явдалд Чингис хаан ихэд зэвүүцэн “Алтан

аргамжаагаа сартуул иргэнээр таслуулаад зүгээр орхиж болох уу. Ухуну тэргүүтэй зуун элчийн өшлийг өшиж, хяслыг хясаж Сартуул улстай байлдъя” хэмээн айлдаж дайтсан тухай Монголын нууц товчооны 224-р талд бичжээ⁶.

Их Монгол улсын эзэн Чингис хаан энэ мэт зайлшгүй шалтгаанаар аян дайн хийх болсон ч гэсэн урьдаар зарлан мэдэгдэх, дайны явц дунд найрамдлын гэрээ хэлэлцээр хийх арга ажиллагааг хэрэглэдэг байсан нь түүний улс хоорондын харилцааны ухаалаг, уян хатан бодлого, үйл хэргийн бас нэг чухал хэсэг байжээ. Ийм зан төлөв, төрх байдал нь жишээлбэл Их Монгол улс Алтан улстай байлдаж байх явц дунд бүрэн илэрч, тэрээр найрамдах, харилцан зөвшилцөх, буулт хийх, цэргээ гэдрэг татах зэрэг санал дэвшүүлж, хэд хэдэн удаа элч илгээж байсан нь талаар болмогц арга буюу дайтан эзлэн авахад хүрч байжээ.

Мөн Тангуд улс 1219 онд Чингис хааны Их Монгол улстай холбоотон байх тохиролцооноосоо урван тэрсэлсэн тул Чингис хаан Тангуд улсад хэрхэн дайн зарлаж, урьдчилан элч зарж мэдэгдсэн тухай Монголын нууц товчооны 265 дугаар зүйлд дурдсан байдаг⁷.

Чингис хааны үеэс Монгол улс Солонгостой найрамдалт харилцаа тогтоох тухай зарлиг гарч байжээ. Харин Монголын элч нар 1225 онд Солонгост очоод буцаж явах замд нь амь насыг хөнөөсөн тул түүнээс болж Монгол-Солонгосын харилцаа 6 жил тасалдсан тухай сурвалж бичигт болон доктор Б.Сумьяабаатарын зохиолд дурдсан байна⁸.

Чингис хаан тийнхүү Их Монгол улсыг байгуулснаас хойш 16 жил буюу 1227 он хүртэл бусад орнуудтай улс төр, эдийн засгийн найрамдалт харилцаатай байхыг ямагт эрмэлзэж, элч төлөөлөгчөө тогтмол илгээж байсан түүхтэй байна. Харин тэр үед Алтан улс, Дундад Ази, Тангуд зэрэг гадаад улс оронд явуулсан хэд хэдэн удаагийн аян дайны тухайд гэвэл тэр нь бусад орны газар нутгийг булааж дээрэмдэх, хүн амыг нь эзэрхэн дарлаж мөлжих, соёл шашныг нь хөнөөж устгах түрэмгий зорилго агуулаагүй, гагцхүү тухайн улсуудын зүгээс Их Монгол Улсад аюул занал байн байн учруулдаг, Чингисийн элч төлөөлөгч нарын амь насанд халдаж хөнөөдөг зэрэг хорлон сүйтгэх явууллага оролдлогод арга буюу цэрэг зэвсгийн хүчээр цохилт өгч буулган авдаг журамтай байжээ. Чингис хааны аян дайны учир шалтгаан, үр дагавар, Чингисийн эрдэм чадал, авъяас билэг, зоригийн талаар Монголын ба гадаадын нэртэй олон түүхч-эрдэмтэн өөрийн бодитой, үнэмшилтэй

үнэлэлт дүгнэлтээ өгч, тодорхойлж бичсэнийг бид цөм мэдэх билээ. Тухайлбал Оросын дорнодахины судлаач, нэрт монголч эрдэмтэн Б.Я.Владимирицов “Чингис хаан” гэдэг алдарт зохиолдоо “. . . хэрэв түүхийн эх сурвалжуудыг анхааралтай шинжлэн судалвал монголын Чингис хаан цус урсгах харгислал, эвдлэн сүйтгэх тэмүүллээр хэзээ ч ялгарч байгаагүй, түүний хүч чадал, ухаан авъяас агуу их байсан ч Чингис тухайн эрин үеийнхээ, өөрийн ард түмнийхээ хүү нь байсан юм. Тиймд түүнийг эрин зууных нь, өөрийнх нь орчин нөхцөлд авч үзвэл зохино. Түүнээс биш өөр цаг хугацаанд, өөр орчин нөхцөлд аваачиж болохгүй. Тэгвэл Чингис хаан . . . тухайн тэр үеийн бусад орны цэргийн эрхтний явуулж байсан аян дайнаас илүү харгис хэрцгий үйл явдал хийж байгаагүй гэдэгт төвөггүй итгэж болно”⁹ хэмээн үнэмшилтэй дүгнэн бичжээ.

Ийм санаа дүгнэлт Монголын А.Амар, Д.Гонгор, Ч.Далай, Н.Ишжамц, Ш.Бира, Ш.Нацагдорж нарын зэрэг олон түүхч, эрдэмтний зохиол бүтээлүүдэд тусгалаа олсон байна. Түүнчлэн Энэтхэгийн Ж.Неру, Оросын Л.Н.Гумилёв, В.П.Васильев, Н.Ц.Мункуев, Персийн Жүвэйни, Хятадын Ван Го-Вэй, Ху Чжао-Си, Америкийн Д.Ж.Вернадский, Солонгосын Паг Венгил нарын зэрэг олон орны олон эрдэмтэн дээрх санаа дүгнэлтийг баталж нотолж бичсэн байна.

Чингисийн энэ үеийн аян дайны өөр нэг ул мөрийн талаар ОХУ-ын эрдэмтэн, академич А.И.Окладников бичихдээ: “Монголын байлдан дагуулал нь Оросын тархай, бутархай олон жижиг Вант улсыг, хүн ардыг нь тэмцэлдээ нэгдэхэд нөлөөлсөн бөгөөд үүний үр дүнд Орос орон нэгдмэл хүчирхэг улс болж тогтносон юм”¹⁰ гэжээ. Хятадын хувьд ийм санааг бас БНХАУ-ын Өвөр Монголын эрдэмтэн Р.Сайшаал өөрийн бичсэн “Чингис хааны товчоон” хэмээх бүтээлдээ дурдсан байна¹¹. Чингис хааны энэ үеийн байлдан дагууллын түрэмгий биш шинж чанарын тухай хуульчлан бататгасан Их Монгол Улсын нэгэн хуулийн талаар хэлэхгүй өнгөрч болохгүй. Чингис хааны “Их засаг” хэмээх алдартай хуулийн нэгэн хэсгийг манай нэртэй эрдэмтэн Б.Сумъяабаатар Солонгос сурвалжаас олж анх удаа олны хүртээл болгож хэвлүүлсэн. Энэ бол Монголоос ч, Европоос ч бидний үе хүртэл олдоогүй, мэдэгдэхгүй байсан зүйл. Аль XIII зууны үед бичигдсэн тэрхүү цаазын бичигт:

Харь бусдын булш бунханг ухаж төнхөж болохгүй.

Эзлэгдсэн орны охид эмстэй хүч түрэмгийлэн гэрлэж сууж болохгүй.

Аян дайны зам зуурын ой төгөл, цэцэг жимсийг сүйтгэж болохгүй гэх мэтийн хэдэн чухал заалт байдаг¹² нь зүй ёсоор анхаарал татаж буй. Иймэрхүү хуульчлал XIII зуунд байтугай бүр хожим ч Европ дахинд, Азид байгаагүй юм билээ.

Бичиг үсэг, хууль эрхийн хувьд гайхалтай боловсронгуй энэ чухал баримт бичиг нь зэрлэг балмад байдлыг цээрлэдэг, үл тэвчдэг зан үйлийнхээ хувьд ч тэр үеийн Монголчууд өндөр соёлтой байсны нэгэн тод жишээ мөн.

Чингис хааны үеийн Их Монгол улсын гадаад харилцааны үйл ажиллагааны өөр нэгэн шинэлэг дэвшилттэй талыг дурдмаар байна. Чингис хаан Их Монгол улсыг байгуулж, ойр, холын олон аймаг, улсыг нэгэн их гүрний дотор нэгтгэж захирахдаа цэрэг дайны болон гадаад харилцааны арга ухааныг нарийсган хэрэглэснээр үл барам тухайн үеийн Өрнө, Дорнод нэрд гарсан эрдэмтэн мэргэд, эмч, шашны төлөөлөгчид, уран дархчуулыг урьж уулздаг, биедээ татаж, Монгол төрийн үйл хэрэгт туслуулан ашиглаж чаддаг байжээ. Энэ бол гадаад харилцаагаа эв, энхийн журмаар хөгжүүлэх чухал алхам, уран ухаан, урлаг мөн байв. Тухайлбал Чингис хаан Хятадын нэртэй эрдэмтэн Чан Чунь Бомбыг урьж уулзсан тухай нэгэн сонирхолтой өгүүллийг академич Н.Ишжамц агсан бичиж нийтлүүлсэн билээ¹³.

Янз бүрийн чиглэл зорилгоор ирэх гадаадын олон элчийг аюул занал, саад бэрхшээл учруулахгүйгээр “хүндэтгэн” хүлээн авдаг байсан нь Их Монгол Улсын дипломат арга ажиллагааны чухал шинж онцлог байв.

Тийнхүү эцэст нь дүгнэж хэлэхэд: нэгд, Монголын Хүннү болон дараа дараах үеийн хаант улсуудын гадаад харилцаа тасралтгүй явагдаж байсан хэдий ч үндэсний нэгдсэн төр улс, түүний нэгдмэл, язгуур эрх ашгийг илэрхийлж чадсан Монголын гадаад харилцааны үндсэн шинж төрх нь Их Монгол улс, эзэн Чингис хааны үед жинхэнэ ёсоор бүрэлдэн бий болжээ; хоёрт, Их Монгол Улсын эхэн үеийн гадаад харилцаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн зарчим, хэм хэмжээнүүдийг бүүр тэр үеэс улс хоорондын харилцааны практикт анхлан хэрэгжүүлж, эх суурийг нь тавьж өгсөн байна; гуравт, Их Монгол Улс, түүний эзэн хаан Чингис гадаад бодлогын хувьд зарим түүхч, зохиолч, улс төрчдийн бичдэгчилэн тийм ч харгис хэрцгий, зэрлэг балмад булаан эзлэгч байгаагүйг бэлхнээ харуулж байна.

ИШЛЭЛ

1. “Монголын эзэнт гүрний гадаад харилцаа” /хамтын бүтээл/, УБ, 1995. 29 дэх талд
2. “Монголын нууц товчоон” /Ц.Дамдинсүрэнгийн эрхлэн нийтлүүлсэн/, УБ, 1990. 195 дах талд
3. “Монголын нууц товчоон” /Ц.Дамдинсүрэнгийн эрхлэн нийтлүүлсэн/, УБ, 1990. 214 дэх талд
4. Ж.Бор “Билгүүн дипломатч Чингис”. УБ, 1994. 47 дахь талд, Ч.Далай “Их Монгол Улс”, УБ, 1996 гэх мэт
5. Ш.Сандаг. “Монголын нэгдсэн тулгар төрийн үүсэл ба Чингис хаан”, УБ, 1984. 50 дах тал
6. “Монголын нууц товчоон” /Ц.Дамдинсүрэнгийн эрхлэн нийтлүүлсэн/, УБ, 1990, 224 дэх тал
7. Мөн тэнд, 265 дах талд
8. Ким Жон Рэ “Мянган жилийн түүхт хүн” /орчуулсан Б.Лхагваа, Ж.Ломбо, Ч.Цэрэнхорлоо/. УБ-Сүүл, 1999, 320 дах тал;
Б.Сумъяабаатар. “XIII-XIV зууны Монгол-Солонгос харилцааны бичгүүд” УБ, 1978, 65-66 дах тал
9. Б.Я.Владимирцов. “Чингис хаан”, УБ, 2001, 49 дэх тал
10. А.И.Окладников. “Первобытная Монголия” Вкн: “Вопросы древнейшей истории Монголии”, М, 1964. 172 дах тал
11. Р.Сайшаал. “Чингис хааны товчоон” /хоёр дахь дэвтэр/, Хөх хот, 1996. 46-47 дах тал
12. Доктор Б.Сумъяабаатартай “ЗГМ” сонины сурвалжлагчийн хийсэн ярилцлага. “ЗГМ”, 1995, №125.